

**11 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**  
Хугацаа-80 минут

Нийт-40 оноо

**А ХУВИЛБАР**

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Аавын уг, хүүгийн үйлс**

Цагийн хүүхэд төдийгүй, цаг яван одоход бодлоо үлдээж чадсан цагийг бүтээгч хөвгүүдийн нэгэн Лодон агсны хүү Түдэвийн тухай өнгөрсөнийг дурдатгал, эдүгээгийн бясалгалаар тодосгон байж энэхүү хөрөг нийтлэлийг бичсүү хэмээн зориглов.

Лодон гуай эргэж ирэхгүй яянд мордохоосоо хэдэн сарын өмнө “Би Чингисийн эр хоёр загал шиг хоёр хүйтэй явлаа. Багыг маань харийн орны Мушгия голын лусын дагина тэвэрч аваад буцааж өгсөнгүй. Тавилан гэдэг энэ биз. Энэ Түдэв л одоо хоёр хүний хийхийг нэгэн биеэр үүрч, хоёр загалын явахыг нэгэн загалын хөлөөр туулах болжээ...” гэснийг нэхэн санав. Ингээд аавын уг, хүүгийн үйлс хоёр найрсан жигдэрч, эцгийн юу санасан есөн хүслийн манлай нь ёсоор бүтсэн сэн. ...

Түдэв ажлын үеэр зохиол бичнэ гэж ер үгүй, зөвхөн оногдсон оногдсонд нь шууд хамаарах ажлаа л хийнэ. Хурдан, халт мөлт болчих вий дээ гэмэр тун хурдан бичнэ. Баллана, сохолно гэж бараг үгүй. Үзэг нь дэгдэн гүйж, хар бэхийн нэг мөр нөгөө мөрөө дэрлэн ундрах нь горхи горхины бидэргээ адил хөвөрнө. Үүнд ер бусын хувилгаан чанар байхгүй ч ширээгдэж төрсөн номч мэргэнд зяядаг чанар буй. Үзэг нь бүдэрнэ ээ гэж үгүй.

**Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном туурвиж, гучад хэлээр нэг сая таван түмэн ширхгээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил тийм ч байхаас яахан аж гэж бодогдно.**

1. Гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой. \ 4 оноо \

.....  
.....  
.....

2. Дараах нийлмэл үгсийг яагаад зэрэгцсэн нийлмэл уг гэж нэрлэснийг тайлбарлаарай.

\ 4оноо \

Бэлэг дурсгал, мөнгө төгрөг, ном дэвтэр, зах зээл, явж одох-

.....  
.....  
.....

3. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийн нөхцөлийг үүргийг тайлбарлаж угсруулан холбох нөхцөлөөр солин найруулж бичнэ үү. \ 4 оноо \

Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном **туурвиж**, гучад хэлээр нэг сая таван түмэн ширхгээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил...

.....  
.....  
.....

4. Эхийн тодруулсан хэсгээс алдаатай 2 үгийг олж дүрмийг тайлбарлана уу. \ 2 оноо \

-  
-  
.....

5. Дараах үгсээс алдаатай үгийг олж зөв болгож бичээрэй. \ 2 оноо \

сурагчдадаа, эмээллээ, бодчихыг, сурчихад, харахыг

.....  
.....  
.....

6. “Эдип хаан” жүжгээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн 50-60 үгэнд багтаан бичээрэй.  
\ 5 оноо \

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

7. “Эдийн ашиг эхэнд, эрдмийн ашиг эцэстээ” сэдвээр 180- 200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Өөрийн үзэл бодолтой холбон олон талаас нь хүүрнэн бичихдээ баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглан, өөрийн үзэл бодлоор эргэцүүлэн бичээрэй. \10 оноо\

8. “Үзэг нь .....адил хөвөрнө” өгүүлбэрт ямар дүрслэх ур маягийг ашигласан байгааг тайлбарлаарай. \ 2 оноо \

.....  
.....

9. “Тэр нэгэн өглөө би хичээлээсээ дэндүү хожимдож, тэр тусмаа Амель багшийн, үйлт нэрийн

тухай биднээс асууна гэсэнд, ганц ч үг, мэдэхгүйдээ тун ч их айж байлаа.” Хэний ямар нэртэй зохиол вэ? \2 оноо\

---

10. Дараах галиг, кирилл бүхий өгүүлбэрийг үндэсний бичгээр бичээрэй. \5 оноо \

Хэд хэдэн салбурийн хэдэн зуун ном түгүрбижу, гучад хэлээр нэг сая табун түмэн ширхэг-ийэр хэблэгүлхү бичгийн хүний үзэг уйаг-а нь тагарагсан хүлэг адил тийм ч байхууч аягахин аж гэж бодугдан-а. 51

---

---

---

---

---

---

---

Анги, бүлэг.....

шифр.....

**11 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**  
Хугацаа-80 минут

Нийт-40 оноо

**Б ХУВИЛБАР**

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Тэр гуай**

Түүний пар пар дуугарч бувтнах нь юун билээ. Нэгэн цагт Тэр гуай хүн шиг хүн төрхтэй явжээ. Инээд ханиад, нөхөрсөг зан, дарвисхийх байдал, дагуулсхийх үг цөм түүний өнгө будаг байжээ. Эдүгээ тэр нь хуурч ойchoод, дотор нь юу чихчихсэн нь үл мэдэгдэх бичгийн цүндгэр цүнх шиг амьтан болчижжээ. Албаны хиймэл маяг бүрнээ тогтоод баахан сургамжлах аяс юм бүхэн дээр гаргана. Бэлхнээ томьёологдсон сонгодгуудын жорыг өмнөө барьж, тэдний нэр төрийг будгаар шавхуурдана.

**Арав хорин жилийн өмнө гүйлгэн харсан бусадын бүтээлийг эдүгээ тэр хэвээр мэт санаж, аливаа юмс урагш хөгжсөөр атал өөрөө нэг байрандаа үлдсэнээ үл ухааран, бусдыг мөн тэр зэргээр бодож, ийм тийм гэж томьёолон, ингүүштэй, тэгүүштэй гэж зааварална.**

Тэр гуай хэрвээ мод юмсан бол эдүгээ бараг бүх навчсаа гүвчихжээ. Хэдхэн ёрдгор мөчир л сэргийж үлдсэн агаад өөрийгөө ямагт зулзган моддын дээгүүр бүрхэж байгаа хэмээн бодож, ямагт доошоо өнгийн харна. Нэг удаа ч болов хажуу тийшээ хяламхийж, агшин ч болов орчноо эргүүлж тойруулж үзээсэй. Тэгвэл дэргэдэх модод чинь хэрхэн ургаж, ямар нь хожуул болон үлдэж вэ? Гэдгийг зэрвэс ч гэсэн үзэхсэн байгаа. Түүний пар пар дуугарч бувтнах нь юун билээ. Ш. Сүрэнжав

1. Гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой. \ 4 оноо \

.....

2. Дараах нийлмэл үгсийг яагаад зэрэгцсэн нийлмэл үг гэж нэрлэснийг тайлбарлаарай.

\ 4оноо \

Нэр тэр, пар пар, инээд ханиад, өнгө будаг, эргүүлж тойруулж

.....

3. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийн нөхцөлийг үүргийг тайлбарлаж угсруулан холбох нөхцөлөөр солин найруулж бичнэ үү. \4 оноо\

Бэлхнээ томьёологдсон сонгодгуудын жорыг өмнөө **барьж**, тэдний нэр төрийг будгаар шавхуурдана.

.....

4. Эхийн тодруулсан хэсгээс алдаатай 2 үгийг олж дүрмийг тайлбарлана уу. \2 оноо\

- .....

5. Дараах үгсээс алдаатай үгийг олж зөв болгож бичээрэй. \2 оноо\

Хэлчихээд, хэлчихсэнийг, туслаж, нөхдөдөө, явбал

.....

6. "Хамелеон" өгүүллэгээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн 50-60 үгэнд багтаан бичээрэй. \5 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. “Эдийн ашиг эхэнд, эрдмийн ашиг эцэстээ” сэдвээр 180- 200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Өөрийн үзэл бодолтой холбон олон талаас нь хүүрнэн бичихдээ баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглан, өөрийн үзэл бодлоор эргэцүүлэн бичээрэй. \10 оноо\

8. Эхээс адилтгасан дүрслэлийг олж тайлбарлана уу. \2 оноо\

9. “Мөчрөөс мөчирт  
Мөлхөн урсах нь  
Хаврын бороо ажээ” Хэний ямар нэртэй зохиол вэ? \2 оноо\

10. Дараах галиг, кирилл бүхий өгүүлбэрийг үндэсний бичгээр бичээрэй. \5 оноо \  
Би арав хорин жилийн эмүн-э гүйүүлгэн харсан бусуд-ун бүтээлийг эдүгэ тэр хэб-ийэр мэт санаж, аливаа *йагумас уругши хөгжигсэгэр* атал өөрөө нэг байрандаа үлэдэгсэн үл ухааран ойлган-а.